Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэрэлт-Од Мөнхтуяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хэрэгжилтийг эрчимжүүлэх | | | | | | | |
| 1 | Аймгийн хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Монгол Улсын Шадар Сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн "Хойд бүсийн хоршоологчдын зөвлөгөөн, өргөтгөсөн худалдаан, арга хэмжээг хамтран зохион байгуулах тухай" 66 дугаар тушаалын дагуу “Шинэ хоршоо – Чинээлэг малчин” арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хойд бүсийн малчид, хоршоологчдод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах зорилгоор "Хоршоологчдын зөвлөгөөн", "Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн худалдаа, арга хэмжээг хамтран зохион байгуулах" арга хэмжээ 2025 оны 04 дүгээр сарын 27,28-ны өдөр Булган аймагт болсон. Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал, Булган аймгийн Засаг | 2-р сар, 3-р сар, 4-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дарга Д.Пүрэв-Очир болон Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 200 орчим малчин, хоршоологчид оролцлоо. Тус арга хэмжээнд Орхон аймгаас хоршооны 20 төлөөлөл оролцсон. Мөн хоршоодод эзэмшүүлэх 5 га газрын зохицуулалт, тэжээлийн ургамал тариалах журмын талаар танилцуулж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бүртгэл, тайлагналтай холбоотой мэдээллийг өглөө.Үүнд: • Зээлийн эргэн төлөлт, анхаарах асуудлууд- Зээлийн батлан даалтын сан • Малын индексжүүлсэн даатгал- Үндэсний давхар даатгал ХХК • Хоршооны гишүүн малчны зээл олголт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зээлийн талаарх танилцуулга- Хаан банк •Хоршоодод эзэмшүүлэх 5 га газар, тэжээлийн ургамал тариалахад хэрхэн хүсэлт гаргах тухай- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар • Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бүртгэл тайлагналт-Татварын ерөнхий газар • Мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, малын гаралтай түүхий эд боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жишиг хоршооны сайн туршлага -3 аймгийн хоршоод танилцуулга мэдээлэл хийсэн. Орхон аймгаас мал аж ахуй чиглэлийн Арга билиг арвин сүрэг хоршоо сайн туршлагаасаа хуваалцсан. | | |
| 2 | Хоршоодыг чадавхжуулах сургалт зохион | Чадавхжуулах сургалтад хамрагдсан | 6 удаагийн сургалт зохион | 3 удаагийн сургалт зохион байгуулж, 180 | Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сумдын Засаг даргын Тамгын газар, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, | 1-р сар, 2-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | хоршоодын тоо | байгуулж, давхардсан тоогоор 170 хүнийг хамруулсан. | хүнийг хамруулах | Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ-тай хамтран хоршоодыг чадавхжуулах, мэдлэг олгох зорилгоор 5 удаагийн сургалтыг давхардсан 131 хүнийг хамруулсан. Сургалтаар •Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөө • Хоршооны сул талууд • Маркетингийн үндсэн ойлголтууд • Маркетингийн хольц • Бизнес тоглоом -1 • Өртгийн сүлжээ • Цагийн менежмент • Нөлөөллийн үйл ажиллагаа хөгжүүлэх нь • Манлайлагчийн зан чанар ба ур чадвар гэх мэт чиглэлээр мэдлэг олгосон. | сар | |
| 3 | "Шинэ хоршоо хөдөлгөөн", Чинээлэг малчин хөтөлбөрийн хүрээнд үр дүнд хүрсэн хоршоодын сайн туршлагыг нэвтрүүлэх, олон нийтэд түгээх, сурталчлах | Хоршоодын тоо | 2 хоршоодын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах ажил хийгдсэн. | 2 хоршоодын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах ажил хийгдсэн. | Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын зээлд хамрагдсан хөдөө аж ахуйн чиглэлийн 3 хоршоодын үйл ажиллагаатай танилцан бүтээгдэхүүнийг иргэдэд олон нийтэд сурталчлах ажлууд хийгдсэн. • Хан наран хулан хоршоо нь нэрийн барааны дэлгүүрээ нээн 10 гаруй нэр төрлийн мах махан бүтээгдэхүүн, цагаан идээгээр хэрэглэгчдэд үйлчилж байна. • Арга билиг арвин сүрэг хоршоо нь сүү, сүүн бүтээгдэхүүн, гэр аргаар бэлтгэсэн бууз, банш, хэрчсэн гурлыг стандартад нийцсэн савлагаатай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, Эрдэнэт хотынхоо 30 гаруй хүсний дэлгүүрт борлуулж байна. • Дарист өгөөж хоршоо нь сүү, сүүн бүтээгдэхүүн, даршилсан ногоо, зайрмаг боловсруулан иргэдэд эрүүл эко бүтээгдэхүүн хүргэхээр зорин ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | "Хоршоог дэмжих сан"-ийн хөнгөлөлттэй зээлд хоршоодыг хамруулах | Хоршоодын тоо | 3 хоршоо 250 сая төгрөгийн зээлд хамрагдсан. | 1 хоршоо хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. | Аймгийн хэмжээнд Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хөдөө аж ахуйн чиглэлийн 4 хоршоонд 422,700,000 төгрөгийн зээл олгогдсон. Зээлд хамрагдсанаар ажлын байр бий болгох, тоног төхөөрөмж худалдаж авах зорилготой юм. | 4-р сар, 5-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 1.2. Ахуйн үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийг дэмжин, үйлчилгээний чанарыг сайжруулах | | | | | | | |
| 5 | Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалт, хамруулсан хүний тоо | 4 удаагийн сургалтад 190 хүнийг хамруулсан. | 3-аас доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. | Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран Үсчин, гоо сайхны салбарт тулгамдаж буй асуудлуудыг 2030 он гэхэд шийдвэрлэж, тухайн салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, тэдний тогтвортой хөгжих боломжийг нээж ажиллах тал дээр үсчин гоо сайхны орон нутгийн холбоонууд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах гарцуудыг нээн ажил хэрэг болгох зорилгоор "Монголын Үсчин Гоо Сайхны Хөгжил – 2030" чуулганыг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Тус чуулганаар 14 аймаг орон нутгийн холбоодууд, 10 гаруй байгууллагууд, 250 гаруй мэргэжилтэнгүүд маань идэвхи санаачлагтай оролцлоо. МҮГС салбарын 5 жилийн стратегийн чухал асуудлуудыг хамтдаа хэлэлцэж, санал дэвшүүлж тодорхой нэг асуудлуудад шийдэл гарц гаргалгааг ярилцсанаар уг чуулган үр дүнтэй болж өнгөрлөө. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 64 хүн | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан. Үүнд: "Бикини ваксны - ONE TOUCH " сургалт. элхийн аварга, Алтан цомын эзэн, Дэлхийн дасгалжуулагч МУ-н мастер Magnai Adiya ДЭЛХИЙН аваргын үзүүлбэрийг үзэх, хэрхэн амжилтад хүрсэн талаарх мэдээллийг өгсөн. | | |
| 6 | Үсчин, гоо засалчдын мэргэжлийн ур чадварын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, уралдааныг зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | "Төв болон хангайн бүс-2024" үсчин, гоо сайхан, хумс засалч дизайн урлалын мэргэжлийн аварга шалгаруулах бүсийн тэмцээнд 6 аймгийн 100 гаруй төлөөлөл оролцсон. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулах | Аймгийн аварга шалгаруулах үсчин, гоо сайханчдын тэмцээнийг 2025 оны 10 дугаар сард Улсын аварга шалгаруулах тэмцээний өмнө зохион байгуулахаар төлөвлөн хугацааг хойшлуулсан. | 4-р сар, 5-р сар | 0% |
| 7 | Ахуйн үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийн түвшинг дээшлүүлэхэд сургалт, сурталчилгааг зохион байгуулж, тохирлын үнэлгээнд хамруулах | Тохирлын үнэлгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 5 иргэн, аж ахуйн нэгжийн 8 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон. | - | 1.Баян-Өндөр сумын ЗДТГ, Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран үсчин, гоо сайхны үйлчилгээнд мөрдөгдөж байгаа "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020,"Хумс заслын үйлчилгээ" MNS 6843:2020 стандартыг сурталчлах, таниулах, чадавхжуулах сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж сургалтад 83 хүн хамрагдсан. Тус сургалтаар дараах чиглэлийн мэдлэг олгосон. 1. Эрх зүйн зохицуулалт, стандартын тухай үндсэн ойлголт 2. Эрүүл ахуй, халдвар | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамгааллын тухай ойлголт 3. Гоёлын гоо засал, хумс заслын үйлчилгээний газрын зэрэглэл, мэргэжлийн зэрэг түвшний мэдээлэл 4. Үс засах үйлчилгээний газрын зэрэглэл, мэргэжлийн зэрэг түвшний мэдээлэл 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухайн ойлголт 6. Нийгмийн даатгалын багц хууль 7. Гал түймрээс урьдчилан сэргийлэх 2. Үүний үр дүнд стандарт хэмжилзүйн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу үсчин засах үйлчилгээ эрхэлж байгаа 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, "Үс засах үйлчилгээ" MNS 5160:2020 стандартын үзүүлэлтийн дагуу бодитойгоор үнэлж, дүгнэн мэргэжлийн зөвлөмж туслалцаа үзүүлэн 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосон. | | |
| 8 | Ахуйн үйлчилгээ эхлэгчдийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах /Үндэсний хувцасны загварын үзүүлбэр, үзэсгэлэн худалдаа, гар урлаачдын уралдаан тэмцээн/ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Жижиг дунд бизнес эрхэлдэг 40 гаруй иргэн, аж ахуй нэгжийг хамруулж нийт 37.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. | 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулах | Ахуйн үйлчилгээний салбарын үзэсгэлэн худалдаа, гар урлаачдын Хангайн бүсийн "Уран гар-2025" уралдааныг 2025 оны 07 дугаар сарын 05,06 -ны өдөр Амрын талбайд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ханган ажиллаж байна. | 6-р сар, 7-р сар | 0% |
| 9 | Үсчин, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж | Үйлчилгээ эрхлэгчдийг 50 хувийг хамруулах | 5 иргэн, аж ахуйн нэгжийн 8 үйлчилгээнд | Үйлчилгээ эрхлэгчдийг 20 хувь хамруулсан | Үсчин, гоо сайхны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүнгэлт өгч, | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн нэгжийг стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүнгэлт өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | | стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүнгэлт өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | байна. | мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилд Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/406 тоот тушаалын хавсралтаар үсчин, гоо сайхны газруудын эрүүл ахуй, халдвар хамгаалал, тус салбарт мөрдөгдөж буй "Үс засах үйлчилгээнд тавих шаардлага" MNS5160:2020, "Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага" MNS5567:2006, "Хумс заслын үйлчилгээний ерөнхий шаардлага" MNS6843:2020 стандартын чиглэлээр төлөвлөгөөт бус шалгалтыг 12 салонд хийж стандартын дагуу нийтлэг зөрчлүүдийг арилгуулсан. | 9-р сар, 10-р сар, 11-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан | Салбарын хууль, дагалдан гарсан хууль | Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс | - | Хүнс, хөдөө аж ахуйн газрын архивд анхан шатны тооллого зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөний дагуу түр | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль 2024 оны 166 дугаар тогтоол /Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай/ | | хадгалах ХН-ийн бодит тоог тогтоох, дотоод товьёг, баталгааны хуудас, дугаарлалт, ашиглалтын хуудасны хөтлөлт бүрэн байдлыг шалгах, өөр хөмрөгт шилжүүлэх шаардлагатай баримтыг илрүүлэх, бүртгэх, шаардлагатай ХН-ийг сэлбэн засах, сэргээн шинэтгэх, тоолж бүртгэх, зөрчилгүй ХН-д баталгаажуулалтыг хийх, тооллогын явцын тэмдэглэл хөтлөх, баримтын тооллогын актыг хөтлөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Ойн мандах ёс зүйн академитай хамтран "Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй" сэдэвт анхан шатны багц сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулж, хууль, байгууллагын соёл, ёс зүйн талаарх мэдлэгийг олгов. Сургалтыг тус академийн захирал, Олон Улсын хуульч/Ph.D/ Ж.Ойнмандах удирдан явуулав. 2022 оны 8 сарын 1-ний өдөр Сангийн сайдын А/155 дугаар тушаалаар | сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлагдсан “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”, “Санхүүгийн тайлан тодруулга бэлтгэх заавар”-ыг ашиглах гарын авлагыг судалж байна. | | |
| 2 | Монгол бичгийн сургалтад хамрагдах | Монгол бичгийн сургалтад хамрагдах | - | Монгол бичгийн сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Засгийн 2020 оны 96 дугаар тогтоол "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд босоо суралцах, унших бичих арга зүй эзэмших сургалтыг байгууллагаас зохион байгуулсан. Тус сургалтыг ерөнхий боловсролын 13-р сургуулийн Монгол бичгийн тэргүүлэх багш анхан болон дунд шатны сургалтуудыг орж зохих мэдлэгтэй болсон. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэрэлт-Од Мөнхтуяа /............................................/ Огноо: ........................